19.10. Шалгалтын дүн импортлох

Шалгалтын дүнгийн мэдээллийг эксел файл дээр бэлдэж татах боломжтой. Импортлох эксел файлын загвар нь системийн **Дата импорт ->Шалгалтын дүн-> Загвар татах -> ExamGradeImportTemplate.xlsx** гэсэн нэртэй файл байна.



Өмнөх нөхцөл

- Суралцагч системд бүртгэгдсэн байх
- Дүнгийн схемийн тохиргоог хийсэн байх
- Шалгалт системд бүртгэгдсэн байх
- Шалгалтад зөв дүнгийн схемийг тохируулсан байх
- Багш системд бүртгэгдсэн байх

Зөвлөмж

- Тоо төрлийн талбарт зөвхөн тоон утга оруулна.
- Огноо төрлийн талбарт он-сар-өдөр форматаар оруулна.
- Текст төрлийн талбарт тоо, үсэг, тэмдэгтээс бүрдсэн мэдээлэл оруулна.
- Ганц сонголт талбарт өгөгдсөн ангиллаас нэгийг сонгоно.
- Заавал бөглөх талбарын өгөгдлийг оруулсан байх.
- Тухайн мэдээлэл дэх код, нэрийг давхцуулахгүйгээр оруулах

Файлын баганын мэдээлэл

Баганы нэр	Төрөл	Тайлбар	Заавал бөглөх талбар эсэх
Сургалтын байгууллагын код	Текст	Сургалтын байгууллагын кодыг оруулна. Энэ нь Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд сургалтын байгууллагыг давхцахгүй байдлаар кодолсон код	Заавал

		юм. Систем тухайн кодоор сургалтын байгууллssагыг танина. Код буруу оруулсан тохиолдолд алдаа заана. Сургалтын байгууллагын кодыг **Систем > Манай байгууллага > Ерөнхий мэдээлэл таб > Үндсэн мэдээлэл хэсэг > Код** талбараас харна уу!	
Оюутны код	Текст	Оюутны кодыг оруулна. Оюутны кодыг **Систем>Суралцагч>Оюутны код** талбараас харна уу!	Заавал
Хичээлийн жил	Ганц сонголт	Хичээлийн жилийг сонгоно.	Заавал
Хичээлийн улирал	Ганц сонголт	Хичээлийн улирлыг сонгоно.	Заавал
Шалгалтын код	Текст	Шалгалтын кодыг оруулна. Шалгалтын кодыг **Систем>Сургалтын агуулга>Шалгалт>Шалгалтын код** талбараас харна уу!	Заавал
Багц цаг	Тоо	Шалгалтыг амжилттай дүүргэснээр олгох багц цагийн дээд хэмжээг оруулна. Хэрэв энд утга оруулахгүй бол систем багц цаг олгодоггүй шалгалт гэж үзнэ. Хэрэв багц цагийг оруулсан бол үүнийг тухайн шалгалтыг амжилттай дүүргэх үед олгосон багц цаг гэж үзнэ.	Заавал
Дүнгийн схем	Ганц сонголт	Дүнгийн схемийг сонгоно. Шалгалтыг дүгнэх дүнгийн схемийг оруулна.	Заавал
Дүнгийн хувь	Тоо	Дүнгийн хувийг оруулна.	Заавал
Дүнгийн оноо	Тоо	Дүнгийн оноог оруулна. Дүнгийн голч бодоход ашиглагдана.	Заавал
Дүгнэсэн огноо	Огноо	Дүгнэсэн огнооыг оруулна.	Заавал
Дүнгийн төлөв	Ганц сонголт	Дүнгийн төлвийг сонгоно.	Заавал
Багшийн код	Текст	Багшийн кодыг оруулна. Сургалтын байгууллагын кодыг **Систем** > **Багш>Багшийн код**	Заавал

		хэсгээс харна уу!	